



Food and Agriculture
Organization of the
United Nations

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙН НЭР ТОМЬЁО

Нянгийн эсрэг үйлчлэл нь антибиотиктой адил

Антибиотик нь нян устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Мөөгөнцрийн эсрэг бодис нь мөөгөнцөр устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Бичил биетний эсрэг бодис нь бичил биетнийг устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Бичил биетний тэсвэржилт нь бичил биетнийг устгадаг эсхүл саатуулдаг бичил биетний эсрэг бодисын төвшрүүлэгт оршин байх болон үржих бичил биетний удамшлын эсхүл олдмол шинж чанар

Шимэгчийн эсрэг бодис нь шимэгчийг устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис.

Эгэл биетний эсрэг бодис нь эгэл биетнийг устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Вирусын эсрэг бодис нь вирусийг задалдаг эсхүл үржлийг нь саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Бактерицид нь нянг устгадаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Бактериостатик нь нянгийн үржлийг саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Өвчинтэй тэмцэх/метафилакс Эмнэл зүйн шинж тэмдэг үзүүлэхийг багасгах эсхүл арилгах, өвчин цааш тархахаас хамгаалах зорилгоор өвчтэй ба эрүүл бодгаль (халдвар авсан гэж үзсэн) агуулсан байгалийн/таримал ургамлын болон мал, амьтны бүлэгт бичил биетний эсрэг бодис олгох эсхүл хэрэглэх

Бичил биетний эсрэг нэн чухал бодисууд (CIA) "ДЭМБ-ээс гаргасан хүн эмнэлэгт хэрэглэх бичил биетний эсрэг нэн чухал эмийн жагсаалт"-ын

хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг нэн чухал бодис

Фунгицид нь мөөгөнцөр устгах шинж чанартай бодис

Фунгистатик нь мөөгөнцрийн үржлийг саатуулдаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Мөөгөнцөр устгадаг бодис нь мөөгөнцрийг устгадаг, байгальд тохиолддог, хагас нийлэг эсхүл нийлэг бодис

Өсөлт идэвхжүүлэх (хэрэглээ) Мал, амьтанд зөвхөн жингийн өсөлтийн эрчмийг нэмэх эсхүл малын тэжээллэгийн үр ашгийг сайжруулах зорилгоор бичил биетний эсрэг бэлдмэл олгох

Бичил биетний эсрэг тэргүүлэх нэн чухал бодисууд (CIA) "ДЭМБ-ээс гаргасан хүн эмнэлэгт хэрэглэх нэн чухал бичил биетний эсрэг эмийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг нэн чухал бодис

Бичил биетний эсрэг маш чухал бодисууд (CIA) "ДЭМБ-ээс гаргасан хүн эмнэлэгт хэрэглэх нэн чухал бичил биетний эсрэг эмийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг маш чухал бодис

Бичил биетний эсрэг чухал бодисууд (CIA) "ДЭМБ-ээс гаргасан хүн эмнэлэгт хэрэглэх нэн чухал бичил биетний эсрэг эмийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг чухал бодис

Хортон шавжтай тэмцэх нэгдсэн менежмент (IPM) нь хортон шавжтай тэмцэх боломжтой бүхий л арга хэмжээг анхааралтай авч үзэн, улмаар хортон шавжийн популяцийн өсөлт хөгжлийг саатуулах, пестицид болон бусад арга хэмжээг эдийн засгийн үндэслэлтэй түвшинд байлгах, хүн, мал, амьтны эрүүл мэнд ба эсхүл хүрээлэн буй орчинд учруулах эрсдэлийг бууруулах эсхүл дээд зэргээр багасгахад чиглэсэн зохистой арга хэмжээнүүдийн нэгтгэл юм. Хортон шавжийн нэгдсэн менежмент нь агроэкоосистемийг хамгийн бага хохирол учруулж болохуйц таримал ургамлын эрүүл ургацын өсөлтийг онцолж, мөн хортон шавжтай тэмцэх байгалийн арга механизмыг дэмжих юм. (ХХААБ/ДЭМБ)

Эмчилгээний ач холбогдолтой бичил биетний эсрэг бодисууд нь хүн эмнэлэгт "бүх ангиллын бичил биетний эсрэг эмийн бэлдмэл" хэрэглэдэг. ДЭМБ-аас гаргасан хүн эмнэлэгт хэрэглэх бичил биетний эсрэг нэн чухал бэлдмэлийн жагсаалт-д тодорхойлсон "молекул бүтцээрээ ижил бүлэгт хамаарч ойролцоо зорилтот зүйлтэй харилцан үйлчлэлд ордог, үйлчлэлийн механизм нь ихэнхдээ ойролцоо учраас тэсвэржилтийн механизм нь төсөөтэй бичил биетний эсрэг бодис"

Бичил биетэн гэж вирус болон Бактери (Археобактер, Эубактер), Мөөг, Протиста, Ургамлын аймгийн нэг эст зүйлийг хэлнэ

Бичил биетний эсрэг бодисын мал эмнэлгийн бус хэрэглээ нь халдварт өвчнийг эмчлэх, тэмцэх, урьдчилан сэргийлэхээс бусад зорилгоор, үүний

дотор өсөлт идэвхжүүлэхээр мал, амьтанд бичил биетний эсрэг бодис хэрэглэх (OIE)

Шимэгч гэдэг нь өөр бие махбодын (эзэн) гадаргуу дээр эсхүл дотор нь амьдардаг, амьд байх нь эзэн амьтнаас авах шим тэжээлээс хамаардаг организм

Хортон шавж нь ургамал, ургамлын бүтээгдэхүүн, материал эсхүл хүрээлэн буй орчинд хөнөөл учруулдаг аливаа төрөл зүйл, омог эсхүл ургамлын биотип, амьтан эсхүл эмгэг төрүүлэгчийг хэлэх ба үүнд эсхүл хүн, мал, амьтны өвчний шимэгч эсхүл эмгэг төрүүлэгч дамжуулагч болон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлж буй амьтан

Пестицид нь аливаа хортон шавжийг үргээх, устгах, тэмцэх, эсхүл ургамлын ургалтыг зохицуулах зориулалт бүхий химийн эсхүл биологийн гаралтай аливаа бодис эсхүл бодисын хольц (ХХААБ/ДЭМБ)

Өвчнөөс урьдчилан сэргийлэх/профилакс бичил биетний эсрэг бодис хэрэглээгүй тохиолдолд өвөрмөц халдвар авах эрсдэлтэй бодгаль эсхүл байгалийн/таримал ургамал, мал, амьтны бүлэгт, эсхүл халдварт өвчин тохиолдох магадлалтай онцгой нөхцөлд бичил биетний эсрэг бодис олгох эсхүл хэрэглэх

Эмчлэх/эмчилгээ нь бичил биетний эсрэг бодисыг халдварт өвчний эмнэл зүйн шинж тэмдэг үзүүлж буй нэг эсхүл бүлэг байгалийн/таримал ургамал эсхүл мал, амьтанд олгох эсхүл хэрэглэх (Кодекс)

Мал эмнэлгийн нэн чухал ач холбогдолтой бичил биетний эсрэг бодисууд "Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан мал эмнэлэгт хэрэглэх чухал бичил биетний эсрэг бэлдмэлийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг нэн чухал бодис

Мал эмнэлгийн маш чухал ач холбогдолтой бичил биетний эсрэг бодисууд "Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан мал эмнэлгийн ач холбогдол бүхий бичил биетний эсрэг бэлдмэлийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг маш чухал бодис

Мал эмнэлгийн чухал ач холбогдолтой бичил биетний эсрэг бодисууд "Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан мал эмнэлэгт хэрэглэх чухал бичил биетний эсрэг бэлдмэлийн жагсаалт"-ын хамгийн сүүлийн хувилбарт ангилсан бичил биетний эсрэг чухал бодис